

## Хураангуй санхүүгийн тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

Далай тауэр 9 даяар, ЮНЕСКО  
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р  
хороо, Улаанбаатар 14230,  
Монгол улс  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street,  
Sukhbaatar District-1, Ulaanbaatar  
14230, Mongolia  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

**“Ард Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:**

### *Дүгнэлт*

Бид “Ард Даатгал” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь “хураангуй санхүүгийн тайлан” гэх) 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь аудитын тайлангийн тодруулгад тайлбарласны дагуу бүхий л материаллаг зүйлсийн хүрээнд аудит хийгдсэн тайлантай нийцэж байна.

### *Хураангуй санхүүгийн тайлан*

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар батлагдсан “Даатгалын компаниудад мөрдөгдөх Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга”-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул “Ард Даатгал” ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2022 оны 3 дугаар сарын 29-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

### *Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт*

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

### *Аудиторын үүрэг хариуцлага*

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын “Аудитын тухай” хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.

  
**Б.ОСОРГАРАВ**  
УДИРДАХ ПАРТНЕР  
Монгол улс, Улаанбаатар хот  
2022 оны 3 дугаар сарын 29